


Эргэн тойронд хэт олон анхааруулах тэмдэг байна уу?

2019 оны 5-р сар

Баруун гар талд буй зургийг нэгэн нисэх онгоцны буудал дээр авсан байна. Энд үзүүлсэн төхөөрөмж ажилчдыг ажиллах цэгт нь хүргэж өгдөг өргөлтийн тавцан юм. Тус тавцан дээр 24 ширхэг анхааруулах тэмдэг харагдаж байна.

Эдгээрийн хэдийг нь оператор анзаардаг гэж та бодож байна вэ? Анхааруулах тэмдэг тус бүр зохих утга санаа, чухал зорилготой гэдэг нь тодорхой. Гэвч бодит байдал дээр хэтэрхий олон тэмдэг байрлуулах нь анхаарал төвлөрөхөд саад болох эсвэл дэндүү төвөгтэй санагдсаны улмаас хэн ч анхаарч харахгүй байх боломжтой юм.

Хэт их мэдээлэл нь бидэнд төвөгтэй санагдах тохиолдол байдаг уу? Тийм! Үйлдвэрлэлийн салбарын хувьд таны хажуугаар нь алхаж өнгөрдөг боловч анхаарч хардаггүй анхааруулах тэмдэг эсвэл аль нэг журам дотор бичигдсэн боловч таны анзаардаггүй анхааруулга зэрэг нь үүний жишээ юм.



Та мэдэх үү?

- Анхааруулах тэмдгүүдийг тухайн ажлын талбайд дээрх тодорхой нэг тоног төхөөрөмж болон үйлдвэрлэлийн аюулын талаар хүмүүст сануулах зорилгоор байрлуулдаг.
- Үйлдвэрлэлийн орчинд эсвэл аль нэг тоног төхөөрөмжийн тусламжтайгаар хийсэн тохиолдолд аюул учруулах зүйлсийг анхааруулах тэмдгүүд дээр тусгайлан заасан байдаг.
- Үйлдвэрлэлийн талбайд байрлуулсан зарим тэмдэг нь шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслүүд (XXX) болон бусад аюулгүй ажиллагааны мэдээллийг харуулдаг. Анхааруулах санамж, шаардлагатай XXX-ийн талаарх мэдээллийг ашиглалт болон засвар үйлчилгээний журам эсвэл ажлын зөвшөөрлийн бичиг баримтуудад мөн тусгасан байдаг.
- Ажлын талбайд байрлуулсан тэмдэг тэмдэглэгээ эсвэл дүрэм журамд тусгасан анхааруулах санамжууд хэт олон байснаар заримыг нь үл анзаарах буюу осол зөрчил тохиолдох боломжтой.

Та юу хийж чадах вэ?

- Үйлдвэрлэлийн талбайд нэвтрэх, тоног төхөөрөмж ашиглахын өмнө ямагт анхааруулах тэмдгүүдийг уншиж танилц. Хэрэгжүүлэх ёстой болон ёсгүй алхмуудыг өөртөө сануул.
- Ашиглалтын журам, засвар үйлчилгээний журам, ажлын зөвшөөрлийн баримт бичигт тусгасан аюулгүй ажиллагаа болон XXX-тэй холбоотой шаардлагуудыг уншиж, ойлгосон байх хэрэгтэй. Тэдгээр шаардлагыг мөрдөж, тухайн шаардлагын талаар ойлгомжгүй зүйлс байвал ахлах ажилтнаасаа асуу.
- Хэрэв бичигдсэн журам эсвэл самбар дээр хэт олон анхааруулах тэмдэг байрлуулсан ба энэ нь хүний анхаарлыг нэн чухал зүйлсэд хандуулахад саад болно гэж бодож байвал ахлах ажилтандаа мэдэгдэх хэрэгтэй.
- Анхааруулах тэмдгүүдийг зөв газар, зохимжтой тоогоор байрлуулсан байна уу? Тэдгээр нь үр нөлөөтэй анхааруулга болж чадаж байна уу? Бүрэн зөв тэмдэг мөн үү?
- Дүрэм журамд тусгасан анхааруулах тэмдэг, санамжуудыг сайжруулах боломжуудын талаарх зөвлөмжийг хуваалц. Жишээ: Дээрх зурагт үзүүлсэн өргөх тавцанд зориулан 24 ширхэг анхааруулах тэмдэг байрлуулсан байсан. Эдгээр 24 ширхэг тэмдгийн заримыг нэгтгэх боломжтой юу? Бүлэглэж болох уу? Хамгийн чухлаар нь ангилж болох уу? Эдгээр тэмдгүүд бүгд шаардлагатай юу?
- Тэмдэг тэмдэглэгээний алдаа доголдолтой холбоотой нэмэлт жишээнүүдийг 2013 оны 5-р сарын *Beacon*-оос харна уу.

Анхааруулах тэмдгүүд бидэнд хэрэгтэй – харин тэдгээр нь байгаа оносон байх ёстой!

© AIChE 2017. Зохиогчийн эрхийг хуулиар хамгаалсан. Арилжаа, худалдааны бус харин сургалтын зорилгоор хуулбарлаж ашиглахыг дэмжинэ. Харин арилжаа, худалдааны зорилгоор AIChE –с бичгээр илэрхийлсэн зөвшөөрөл аваагүй тохиолдолд хуулбарлаж ашиглахыг хатуу хориглоно. Билдэгтэй ccps.beacon@aiiche.org эсвэл 646-495-1371 хаягаар холбогдоно уу.